

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны хамтарсан/.... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

СПОРТЫН КЛУБИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт хараат бус үнэлгээ хийж, мэргэжлийн дүгнэлт өгөх магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Спортын клуб гэдгийг Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь хэсэгт зааснаар ойлгоно.

1.3. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагдах ба нээлттэй, ил тод, тэгш, шударга ёсны зарчимд тулгуурлана.

1.5. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клуб нь энэхүү журмын дагуу үйлчилгээний төлбөр төлнө.

Хоёр. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Биеийн тамир, спортын төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Спортын клубыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах орон тооны бус зөвлөл (цаашид зөвлөл гэх) ажиллана.

2.2. Спортын клубын магадлан итгэмжлэх зөвлөл 15 гишүүнтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.3. Зөвлөл нь Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлтийг хэлэлцэж магадлан итгэмжлэл олгох тухай зөвлөлийн шийдвэрийг гаргана.

2.4. Биеийн тамирын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь магадлан итгэмжлэлийн бодлогыг тодорхойлж , нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.1. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцогч талуудыг нэгдсэн удирдлагаар хангах

2.4.2. Магадлан итгэмжлэлийн шинжээчдийг томилох, сунгах, чөлөөлөх

2.4.3. Магадлан итгэмжлэл олгох тухай шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргаж батламж олгох, цуцлах

2.4.4. Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

2.4.5. Магадлан итгэмжлэлийн чиглэлээр мэргэжлийн байгууллага болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог хангах

2.4.6. Магадлан итгэмжлэлийн өдөр тутмын үйл ажиллагааг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэгж хэрэгжүүлнэ.

2.5 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэн халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, амьдралын эрүүл хэв маяг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, зөвлөмжөөр хангах, орчны болон нэгдсэн бодлогыг тодорхойлоход дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.5.1. Спортын клубын магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд орчны болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн чиг үүргийн дагуу хараат бус шинжээчдийг гэрээний үндсэн дээр ажиллуулах,

2.5.2. Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгчид, спортын клубын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан зөвлөмж, мэдээ, мэдээллээр хангах,

2.5.3. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгчдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэнд хяналт тавих,

2.6. Биеийн тамир, спортын төрийн захиргааны асуудал хариуцсан биеийн тамирын нэгж нь дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

2.6.1. Магадлан итгэмжлэлийн шинжээчдийг сонгон шалгаруулалт зохион байгуулах, шалгаруулах, шинжээчдийг томилох, чөлөөлөх хүсэлт уламжлах

2.6.2. Спортын клубын магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг хүлээн авах

2.6.3. Магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг хянан үзэж, шаардлага хангасан спортын клубүүдийг магадлан итгэмжлэлийн жагсаалтад тусгах

2.6.4. Магадлан итгэмжлэлийн жагсаалтад туссан спортын клубүүдэд ажиллах шинжээчдийн багийн бүрэлдэхүүн, ажиллах хугацаа, дүгнэлт гаргах хугацааг Биеийн тамир, спортын төрийн захиргааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлуулах

2.6.5. Шинжээчдийн багийн дүгнэлтийг нэгтгэж магадлан итгэмжлэл олгох хүсэлтийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилах

2.6.6. Магадлан итгэмжлэл олгох тухай шийдвэрийг үндэслэн батламж олгох үйл ажиллагааг зохион байгуулах, цуцлах

2.6.7. Спортын клубын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан зөвлөмж, мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх

2.6.8. Магадлан итгэмжлэлийн чиглэлээр мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах

2.6.9. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрыг мэргэжил арга зүйгээр хангах, сургах, хамтран ажиллах

2.6.10. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх.

2.7. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар нутаг дэвсгэртээ магадлан итгэмжлэлийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.7.1 Спортын клубын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан зөвлөмж, мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх

2.7.1. Магадлан итгэмжлэлийн хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх

2.7.2. Спортын клубд хийгдэж буй магадлан итгэмжлэлийн үнэлгээгээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээнд хяналт тавих

2.7.3. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагад хүсэлт уламжлах, шийдвэрлэх

2.7.4. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх.

2.8. Спортын магадлан итгэмжлэлийн шинжээч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.8.1. Спорт клубийг магадлан итгэмжлэх шинжээчийн багийн бүрэлдэхүүнд эрүүл мэнд, стандарчилал хэмжил зүй, барилга, эрүүл ахуй, боловсролын байгууллагыг магадлан итгэмжлэх эрх бүхий шинжээчийг шууд ажиллуулж магадлан итгэмжлэх дүгнэлт гаргах эрх бүхий хараат бус шинжээч, байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, сургалт зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх,

2.8.2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шат бүрд спортын клубд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, чиглүүлэх, зөвлөн туслах, хамтран ажиллах

2.8.3. Магадлан итгэмжлэх байгууллага, спортын клубд магадлан шинжилгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж шинжээчдэд 2 долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.

2.8.4. Шинжээч нь магадлан итгэмжлэх байгууллагатай эдийн засгийн харилцаа холбоогүй, удирдлагын багийн гишүүдтэй төрөд садан биш байна.

2.8.5. Шинжээчид байгууллагын магадлан шинжилгээнд оролцсон хугацаа, ажлын үр дүнг нь харгалзан магадлан итгэмжлэх байгууллага ажлын хөлс олгоно.

2.9. Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар бүрдүүлнэ.

2.9.1 Үйл ажиллагааны магадлан итгэмжлэл хийх шинжээчийн багийн бүрэлдэхүүнд санхүү эдийн засаг, хууль эрх зүй, эрүүл мэнд, стандарчлал, хэмжил, зүй, боловсрол, биеийн тамир, спорт, удирдлагын менежментийн мэргэжилтэн шинжээчид ажиллана.

2.9.2 Сургалт-дасгалжуулалтын магадлан итгэмжлэл хийх шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд эрүүл мэнд, стандарчлал, хэмжил, зүй, барилга, эрүүл ахуй, биеийн тамир, спорт, боловсрол, хууль эрх зүй, санхүү эдийн засаг, маркетинг- менежментийн мэргэжилтэн шинжээчид ажиллана.

Гурав. Шинжээч сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх

3.1. Спорт клубийг магадлан итгэмжлэлийн шинжээчийг сонгон шалгаруулж, шаардлага хангасан шинжээчийг 2 жилийн хугацаатай “Спортын магадлан итгэмжлэлийн шинжээч”-ээр томилно.

3.2. Спортын магадлан итгэмжлэлийн шинжээч нь дахин шинжээчээр ажиллах бол сонгон шалгаруулалтад оролцож, шаардлагыг хангансан тохиолдолд 2 жилийн хугацаатайгаар дахин томилогдоно.

3.3. Спортын магадлан итгэмжлэлийн шинжээч болох хүсэлтийг хувь хүн гаргаж болох ба нарийн мэргэжлийн чиглэлийн шинжээчийг эрх бүхийн байгууллага нэр дэвшүүлнэ. Шинжээч дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1 Мэргэжлийн эрдмийн зэрэг, цолтой,

3.3.2. Байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай, мэргэшсэн

3.3.3 Тухайн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байсан туршлага бүхий

3.3.4 Мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан

3.3.5. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй

3.4. Шинжээчийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ:

3.4.1. Өргөдөл

3.4.2. Биеийн байцаалт /төрийн албан хаагчийн анкет 1-р маягтаар/,

3.4.3. Иргэний үнэмлэхийн хуулбар

3.4.4. Боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар

3.4.5. Шинжээчээр ажиллахыг дэмжсэн байгууллага, хамтран ажиллаж байсан 2 хүний тодорхойлолт

3.4.6. 2 хувь цээж зураг

3.5. Магадлан итгэмжлэх байгууллага шаардлага хангасан этгээдийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад “Спортын магадлан итгэмжлэлийн шинжээч”-ээр томилуулахаар уламжилна.

3.6. Магадлан итгэмжлэх байгууллага нь томилогдсон шинжээчтэй гэрээ байгуулж ажиллана.

3.7. Магадлан итгэмжлэх байгууллагаас шинжээчийг магадлан итгэмжлэх арга зүйн сургалтанд хамруулна.

3.8. Шинжээч нь мэрэгжлийн зөрчил гаргасан бол магадлан итгэмжлэх байгууллага шинжээчийн чөлөөлөх хүсэлтийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3.9. Дөрвөн жил тутам шинжээчдийн багийн гуравны нэг шинэчлэгдэж байх ба шинжээчээр 4 /8/ жил ажилласан мэргэжилтэн 2 /4/ жил завсарласны дараа дахин шинжээчээр ажиллах хүснэлт гаргаж болно.

Дөрөв. Шинжээчийн эрх, үүрэг

- 4.1. Спорт клубийг магадлан итгэмжлэх шинжээчийн багийн бүрэлдэхүүнд эрүүл мэнд, стандарчилал хэмжил зүй, барилга, эрүүл ахуй, боловсролын байгууллагыг магадлан итгэмжлэх эрх бүхий шинжээчийг шууд ажиллуулж магадлан итгэмжлэх дүгнэлт гаргах эрх бүхий хараат бус шинжээч, байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, сургалт зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх,
- 4.2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шат бүрд спортын клубд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, чиглүүлэх, зөвлөн туслах, хамтран ажиллах

Тав. Магадлан итгэмжлүүлэх спортын байгууллагад тавигдах шаардлага

Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй спортын клуб нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 5.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байх,
- 5.2. Үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан, зориулалтын байртай байх,
- 5.3. Үйлчилгээ үзүүлж буй спортын төрлөөр тухайн спортын Монголын холбоонд албан ёсоор бүртгэлтэй, тухайн спортын төрлөөр сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх авсан байх,
- 5.4. Үйлчилгээ үзүүлж буй спортын төрлөөр сургалт-дасгалжуулалт удирдах эрх бүхий дасгалжуулагчтай байх,
- 5.5. Магадлан итгэмжлэлд орох асуудлыг хамт олноороо хүлээн зөвшөөрсөн байх,
- 5.8. Магадлан итгэмжлэлд бэлтгэх зөвлөгөө авч, сургалтад хамрагдсан байх,
- 5.9. Магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх,
- 5.10. Бүрдүүлсэн баримт бичгүүд үнэн, бодитой байх.

Зургаа. Спортын клубын магадлан итгэмжлэлийн үе шат

6.1. Спортын клуб нь өөрийн хүсэлтээр магадлан итгэмжлэлд хүсэлт ирүүлнэ. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг дараах үе шатуудад хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.2. Магадлан итгэмжлэлд бэлтгэх үе шат

- 6.2.1. Спортын клуб нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргахаас өмнө стандартын шаардлага болон энэхүү журмын шаардлагыг хангасан талаарх мэдээллийг журмын хавсргаж ирүүлнэ.
- 6.2.2. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үнэлгээг оролцоонд тулгуурлан хийж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудалд чиглэсэн чанар сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, дүгнэсэн байх.
- 6.2.3. Магадлан итгэмжлэлийн чиглэлээр аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар, ажлын албанаас ажлын байран дахь арга зүйн зөвлөгөөг авах, зөвлөмжийг хэрэгжүүлэх, дүгнэх
- 6.2.4. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хүрээнд өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах
- 6.2.5. Хараат бус үнэлгээний багийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулсан, үр дүн гарсан байх.
- 6.3. Магадлан итгэмжлэх үе шат
 - 6.3.1. Магадлан итгэмжлэгдсэн тухайгаа өөрийн байгууллагын цахим хуудсаар мэдээлэх
 - 6.3.2. Магадлан итгэмжлэлийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах, зөвлөмжийг хэрэгжүүлэх
 - 6.3.3. Өөрийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанар, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн дүгнэх, үйлчилгээний чанар, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
 - 6.3.4. Хэрэв давтан магадлан итгэмжлэлд орох бол магадлан итгэмжлэлд бэлтгэж, энэхүү журмын 6.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Долоо. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах, баримт бичиг бүрдүүлэх

- 7.1. Спортын клуб нь магадлан итгэмжлэлд орох бэлтгэлийг хангасны дараа энэхүү журмын 7.3-т заасан баримт бичгийг бүрдүүлнэ.
- 7.2. Давтан магадлан итгэмжлэлд орох спортын клуб нь батламжийн хүчинтэй хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө хүсэлтээ гаргана.
- 7.3. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах спортын клуб нь дараах баримт бичгийг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлэн, баталгаажуулна. Үүнд:
 - 7.3.1. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт бүхий албан бичиг,
 - 7.3.2. Спортын клубийн танилцуулга,
 - 7.3.3. Спортын төрөл тус бүрээр сургалт-дасгалжуулалт эрхлэх спортын холбооны зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,

- 7.3.4. Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /анх удаа орох байгууллагад хамаарахгүй/
- 7.3.5. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр хийсэн өөрийн үнэлгээний тайлан,
- 7.3.6. Үйлчлүүлэгчийн болон ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд хийсэн дүн шинжилгээний тайлан.
- 7.3.7. Спортын клуб үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалт эрхлэх өөрийн өмчлөлийн байргүй тохиолдолд 2-оос доошгүй жилийн хугацаанд тогтвортой түрээсээр үйл ажиллагаа, сургалт дасгалжуулалт явуулах байрны өмчлөгчтэй хийсэн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, өмчлөгчийн өөрийн өмчлөлийн байранд магадлан итгэмжлэл хийлгэхийг зөвшөөрсөн болон магадлан итгэмжлэлийн зөвлөмжийг биелүүлэх баталгаа бүхий албан бичиг, /өөрийн өмчлөлийн байртай спортын клубд хамаарахгүй/
- 7.3.8. Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын тайлан,
- 7.3.9. Магадлан итгэмжлэгдэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт

Найм. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах баримт бичигт тавигдах шаардлага

- 8.1. Спортын клуб нь баримт бичгийг цаасан болон CD хэлбэрээр бүрдүүлж, харьяа аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газарт хүргүүлнэ.
- 8.2. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар спортын клубийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт баримт бичгийг авч материал бүрдүүлэлтэд хяналт тавина.
- 8.3. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар спортын клубийн ирүүлсэн шаардлага хангасан баримт бичгийг цаасан болон CD хэлбэрээр хүлээж авснаас хойш ажлын 15 хоногт багтаан энэхүү журмын 8.5-д заасан ажлыг зохион байгуулж ажлын албанд ирүүлнэ.
- 8.4. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудад спортын клубийн баримт бичгийг хүлээж авснаас хойш ажлын 15 хоногийн дотор хянан үзэж, баримт бичиг бүрэн бус, шаардлага хангаагүй бол тухайн спортын клубд буцааж, баримт бичиг буцаасан тухай аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газарт албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.5. Баримт бичиг бүрэн, шаардлага хангасан тохиолдолд ажлын 15 хоногийн дотор шинжээчийн баг ажиллуулах товыг гаргаж, хүсэлт гаргасан спортын клуб болон аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газарт мэдэгдэнэ.

- 8.6. Спортын клубийн нэр өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд үндэслэн магадлан итгэмжлэлийг батламжийг хүсэлт гаргасан хойш ажлын 10 хоногт багтаан дахин олгоно.

Ес. Магадлан шинжлэх, үнэлгээ хийх

- 9.1. Спортын клубийн үйлчилгээний төрөл, цар хүрээнээс хамаарч 3-аас доошгүй хараат бус шинжээчийн бүрэлдэхүүнтэй баг нэг клубд 1-3 өдөр ажиллана.
- 9.2. Хараат бус шинжээчийн баг үнэлгээ хийх байгууллагын баримт бичигтэй урьдчилан танилцаж, мэдээлэл авсан байна.
- 9.3. Хараат бус шинжээчийн баг үнэлгээ хийх байгууллагын удирдлага, ажилтнуудтай уулзаж ажлын төлөвлөгөөг танилцуулж, төлөвлөгөөний дагуу ажиллана.
- 9.4. Хараат бус шинжээчийн баг нь баримт бичгийн үзлэг, гардан хийх үйл явцад ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг аргуудыг үнэлгээнд ашиглана.
- 9.5. Хараат бус шинжээчийн баг үнэлгээтэй холбоотой нэмэлт баримт бичгийг тухайн байгууллагаас гаргуулан авч болон.
- 9.6. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр хийгдсэн үнэлгээний урьдчилсан дүгнэлт, сайжруулах ажлын зөвлөмжийг тухайн байгууллагын удирдлага, нийт ажилтнуудад танилцуулж, 2 хувь тэмдэглэл үйлдэн байгууллагад нэг хувийг үлдээнэ.
- 9.7. Ажлын тайлан, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, танилцуулгыг батлагдсан маягт, аргачлалын дагуу боловсруулж, үнэлгээ хийсэн байгууллагын тооноос хамаарч ажлын 3-7 хоногт багтаан цаасан болон цахим хэлбэрээр багийн ахлагч ажлын албанд ирүүлнэ. Багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 9.8. Ажлын алба нь хараат бус шинжээчийн багийн ирүүлсэн баримт бичгийг хянаж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангана.
- 9.9. Хараат бус шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлтийг үнэлгээ хийснээс хойш 30 хоногийн дотор зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөмжийг спортын клубд хүргүүлнэ.
- 9.10. Магадлан итгэмжлэл авснаас хойших хугацаанд спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын үйлчилгээний төрөл болон үйлчилгээ эрхэлдэг байр өөрчлөгдсөн тохиолдолд магадлан итгэмжлэлд анх удаа орж байгаа гэж дүгнэж үнэлнэ.

Арав. Магадлан итгэмжлэл олгох, сунгах

- 10.1. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн анх удаа магадлан итгэмжлэгдсэн спортын клубд 1, 2 жилийн хугацаатайгаар, давтан магадлан итгэмжлэгдсэн

байгууллагад үнэлгээний дүнг харгалзан 2-5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэлийг олгож, баталгаажуулна.

- 10.2. Спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын үйлчилгээний төрөлд өөрчлөлт ороогүй, тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш удаа тасралтгүй магадлан итгэмжлэгдсэн бол ажлын алба, аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын хийсэн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн хугацааг сунгах эсэх тухай саналыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ. Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 3 жилийн хугацаагаар магадлан итгэмжлэлийн хугацааг зөвхөн нэг удаа сунгах ба байгууллага нь үйлчилгээний батлагдсан жишгээр төлбөр төлнө.
- 10.3. Магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт тус бүрийг 100 хувийн үнэлгээгээр үнэлнэ. Шалгуур үзүүлэлтийн бүлэг тус бүрийн үнэлгээний босго нь анх удаа магадлан итгэмжлэлд орж байгаа спортын клубд 80 ба түүнээс дээш хувь, давтан орж буй спортын клубд 85 ба түүнээс дээш хувь байгаа тохиолдолд шалгуур үзүүлэлтийг хангасан гэж дүгнэнэ.
- 10.4. Анх удаа магадлан итгэмжлэгдэх спортын клуб шалгуур үзүүлэлтийг 80-89,9 хувь хангасан бол 1 жил, 90 ба түүнээс дээш хувь хангасан бол 2 жил, давтан магадлан итгэмжлэгдэх спортын клуб 85-88,9 хувь хангасан бол 2 жил, 89-91.9 хувьд 3 жил, 92-95.9 хувьд 4 жил, 96-аас дээш хувьд 5 жилийн хугацаатайгаар тус тус олгоно.
- 10.5. Түрээсийн байранд үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулах үйлчилгээ үзүүлдэг давтан магадлан итгэмжлэгдэх спортын клубийн хувьд 85-89.9 хувь хангасан бол 1 жил, 90.0 хувиас дээш хангасан бол 2 жилийн хугацаатайгаар олгоно.
- 10.6. Магадлан итгэмжлэх хугацаа дууссанаас хойш магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд анх удаа магадлан итгэмжлэлд орсноор тооцож үнэлнэ.
- 10.7. Хараат бус шинжээчийн багийн үнэлгээгээр магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт хангаагүй спортын клубд магадлан итгэмжлэл олгохгүй бөгөөд шийдвэрийг тухайн спортын клуб, харьяалах аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газарт шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ. Хэрэв тухайн асуудал спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын үйлчилгээ, байр талбайн аюулгүй байдалтай холбоогүй үзүүлэлт бол зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 3 сарын хугацаа өгч, дахин тухайн чиглэлд хараат бус шинжээчийн үнэлгээг хийлгэж болон.
- 10.8. Спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын үйлчилгээнд гарсан зөрчил, дутагдалтай холбоотой асуудлын улмаас магадлан итгэмжлэл олгохыг түдгэлзэж, тодорхой хугацааны дараа дахин

шийдвэрлэсэн тохиолдолд батламжийг зөвлөлийн хурлын шийдвэр гарсан өдрөөс олгоно.

10.9. Энэхүү журмын 10.6, 10.8-д зааснаас бусад тохиолдолд дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг 12 сарын дараа гаргаж болон.

Арван нэг. Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох

11.1 Магадлан итгэмжлэлийг дор дурдсан нөхцөлд хүчингүй болгоно. Үүнд:

11.1.1. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалт эрхлэх үйлчилгээнд эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм, хичээллэгчийн аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөний улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон талаар үйлчлүүлэгчдийн гомдол гарсан, үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалт явуулах стандарт удаа дараа зөрчигдсэн нь явцын хяналт, үнэлгээ болон хяналт, шалгалт хийх эрх бүхий байгууллагаар нотлогдсон,

11.1.2. Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дууссан,

11.1.3. Үйлчлүүлэгчээс төрийн захиргааны байгууллагад тухайн спортын клубийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, ёс зүйтэй холбоотой гомдол нийт үйлчлүүлэгчдийн 1 ба түүнээс дээш хувьд гарсан, гомдлыг барагдуулж тодорхой арга хэмжээ аваагүй бол,

11.1.4. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын үйлчилгээний чиглэл өөрчлөгдсөн, эсхүл байгууллага татан буугдсан, дампуурсан, 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоосон бол,

11.1.5. Магадлан итгэмжлэгдсэн хугацаанд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хангалтгүй дүгнэгдсэн бол,

11.1.6. Магадлан итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдсаны дараа үйлчилгээ үзүүлж буй ажлын байр, эсхүл сургалт-дасгалжуулалтын төрөл, нэмэгдсэн, өөрчлөгдсөнөө тухай бүр мэдэгдээгүй бол.

Арван хоёр. Маргааныг шийдвэрлэх

12.1. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар гарсан маргааныг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

12.2. Спортын клуб нь хараат бус шинжээчдийн багийн өгсөн дүгнэлттэй санал нийлэхгүй, эсхүл шинжээчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гомдол гарвал магадлан итгэмжлэх зөвлөлд хүсэлт гаргаж хараат бус шинжээчдийн хоёр дахь багийг томилуулж болон.

12.3. Хараат бус шинжээчийн хоёр дахь баг томилон ажиллахтай холбогдон гарах зардлыг тухайн хараат бус шинжээчийн баг томилсон байгууллага хариуцна. Энэхүү хоёр дахь багийн дүгнэлт нь магадлан итгэмжлэх байгууллагын эцсийн шийдвэрийн үндэслэл болон.

- 12.4. Спортын клуб нь зөвлөлийн гаргасан саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гомдол гаргаж болон.
- 12.5. Зөвлөлийн хурлын шийдвэрээр шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар дахин хэсэгчилсэн үнэлгээ хийж болно.

-oOo-

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайд, Эрүүл мэндийн сайдын
2018 оны хамтарсан .../.... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

СПОРТЫН КЛУБИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Шалгуур үзүүлэлтийн ангилал

1.1. Спортын клубийн магадлан итгэмжлэлийн хараат бус шинжээчид магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубийн иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт магадлан итгэмжлэлийн үнэлгээг дараах ангилал тус бүрээр үнэлж дүгнэнэ. Үүнд:

1.1.1. Ерөнхий шалгуур

1.1.2. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур

1.1.3. Сургалт-дасгалжуулалтын чанарын шалгуур

1.2. Магадлан итгэмжлэлийн үнэлгээний нийт үнэлгээг энэхүү журмын 1.1.1-1.1.3-т ангилсан шалгуур бүрээр тусад нь дүгнэх бөгөөд аль нэг ангиллын үнэлгээ 60-аас доош үнэлгээ авсан тохиолдолд магадлан итгэмжлэл олгохгүй байх үндэслэл болон.

Хоёр. Нийтлэг шалгуур

2.1. Нийтлэг шалгуур үзүүлэлт нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубийн Монгол улсын холбогдох хуулиар хүлээсэн нийтлэг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгаад өгөх үнэлгээ юм.

2.2. Нийтлэг шалгуур

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
1.	Хууль, эрх зүйн чадамж	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, шаардлагатай бол мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл.	0-1	40
		Тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл <u>хуудасны</u> бүрдэл, харилцах данс	0-3	40
		Байгууллагын батлагдсан дүрэм, журам, бүтэц орон тоо, стратеги /бизнес/ үйл ажиллагааны жилийн	0-4	40

		төлөвлөгөө		
		Мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан ажлын байрны дүгнэлт	0-1	40
2.	Санхүү, эдийн засгийн чадамж	Татвар, даатгал, хяналтын мэргэжлийн байгууллагын дүгнэлт	0-5	35
		Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байдал	0-2	35
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт	0-1	35
		Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдал, тодорхойлолт	0-2	35
		Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, гэрчилгээ, эргэлтийн хөрөнгийн байдал	0-2	35
		Хөрөнгө оруулалтын хэмжээ, төлөвлөгөө	0-3	35
3.	Хуулиар үүргийн чадамж хүлээсэн хэрэгжүүлэх	Цалин, урамшуулал, хөдөлмөр хамгааллын нөхцөл, ажилчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	0-5	15
		Статистик, бүртгэл судалгааны материал, архив, бичиг хэргийн хөтлөлт	0-2	15
		Дотоод хяналт, ил тод байдлын хэрэгжилт	0-2	15
		Байгууллагын үйл ажиллагааны тайлан, дүрэм, дотоод журмын биелэлт	0-5	15
4.	Бусад	Нийгмийн үүрэг, хариуцлагын хэрэгжилт	0-5	10
		Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа	0-5	10

		Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	0-5	10
--	--	--------------------------------	-----	----

Хоёр. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур

- 2.1. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуураар магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубийн үйл ажиллагаа явуулж буй барилга, байгууламж, заал, талбай, танхимын үйлчлүүлэгчдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үеийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага, хэрэгцээг хангасан байдалд өгөх үнэлгээ болон.
- 2.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубийн үйл ажиллагаа эрхэлдэг байр, талбай, заал, танхим нь өөрийн өмчлөлийн биш тохиолдолд үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуурт үнэлгээ өгөхөд өмчийн эзэмшигчийн төлөөллийг заавал байлцуулна.
- 2.3. Үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур:

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
1.	Спортын клубийн үйлчилгээ үзүүлэх орчны нийтлэг стандартын хэрэгжилтийн шалгуур	Өмчийн гэрчилгээ эсвэл түрээсийн гэрээ	0-5	40
		Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ. Нийтлэг шаардлага MNS 5538:2005	0-3	40
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000	0-3	40
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага. MNS 4996:2000	0-3	40
		Агааржуулалтын систем. Ерөнхий шаардлага MNS 0012-4-006:1985	0-3	40
		Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5525:2005	0-3	40

		Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5390:2004	0-3	40
		Цанын бааз, мөсөн гулгуурын талбайн үйлчилгээ.Ерөнхий шаардлага стандарт. MNS 6000:2009	0-3	40
2.	Үйл ажиллагаанд мөрдлөг болгох эрх зүйн бичиг баримт, судалгааны шалгуур	Эрүүл мэндийн сайдын 2010 оны 49 тоот тушаал "Тамирчдын ажиллах чадварыг хязгаарлагч хүчин зүйлсийг эмийн хэрэглээгээр зохицуулах удирдамж"	0-3	35
		"Биеийн тамир, спортоор хичээллэгчдэд тавих эмнэлгийн хяналт, үйл ажиллагааны сорилын удирдамж"	0-3	35
		Биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч. MNS 5323-12:2004	0-3	35
		Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ үйлчилгээний түгээмэл үйлдлүүд MNS 4621:1998	0-3	35
		Туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг ахиулах, дадлагажуулах сургалтад хамруулсан байдал	0-3	35
		Ажиллагсдын эрүүл мэнд, хувийн хэргийн бүрдүүлэлт, дэлгэрэнгүй судалгаа	0-3	35
3.	Үйл ажиллагаатай холбоотой бусад шалгуур	Төлбөр, хураамжийн хэлбэр байдал	0-3	25
		Батлагдсан үйлчилгээний төлбөр хураамжийн тариф	0-3	25
		Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдал	0-3	25

	Үйлчилгээ үзүүлэх журам бусад лавлагаа мэдээллийг ил тод байрлуулсан байх	0-3	25
	Санал, хүсэлтийн хайрцаг ажиллуулах, түүний шийдвэрлэлт	0-3	25
	Ажилтан, албан хаагчдын ёс зүй, ур чадвар, харилцааны соёл	0-3	25
	Хичээллэгчдийн дэлгэрэнгүй бүртгэл, судалгаа	0-3	25
	Тухайн үйлчлүүлэгчид зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөр	0-3	25
	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө хийсэн байдал	0-3	25
	Эрдэм шинжилгээ, судалгаа хийсэн, үнэлгээ, статистик дүн мэдээ гаргасан байдал	0-3	25
	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийсэн байдал	0-3	25
	Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, оролцсон байдал	0-3	25
	Нийгмийн үйл ажиллагаанд оролцсон байдал	0-3	25

Гурав. Сургалт-дасгалжуулалтын чанарын шалгуур

- 3.1. Сургалт-дасгалжуулалтын чанарын шалгуураар тухайн спортын клубийн сургалт-дасгалжуулалт эрхлэхээр тухайн спортын холбооноос авсан зөвшөөрөл, сургалт-дасгалжуулалт эрхлэх дасгалжуулагч, арга зүйчид тавигдах шаардлага, мэдлэг ур чадвар, үйлчилгээнд баримтлах стандартын хэрэгжилт болон хичээллэгчдийн бие бялдрын төвшин, спортын амжилт зэрэгт үнэлгээ өгнө.
- 3.2. Сургалт-дасгалжуулалтын үнэлгээг

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
---	---------	----------	---------	------

1.	Сургалт- <u>дасгалжуулалтын</u> үйлчилгээ эрхлэх орчны стандартын шалгуур	Тухайн төрлийн спортын холбооны зөвшөөрөл	0-1	30
		Тухайн төрлийн стандартын хэрэгжилт	0-5	30
		Тухайн төрлийн стандартад заасан орчны шаардлага хангасан байдал /стандарт тус бүрээр/	0-5	30
		Нэг ээлжид хичээллэгчдийн тоо, бүртгэл, судалгаа	0-3	30
		Стандартын дагуу боловсруулсан сургалт- <u>дасгалжуулалтын</u> төлөвлөгөө	0-5	30
2.	Хүний нөөцийн мэргэжил, ур чадварын шалгуур	Дасгалжуулагчийн мэргэжил, Боловсролын гэрчилгээ, ур чадварын үнэлгээ	0-5	35
		Арга зүйчийн мэргэжил, Боловсролын гэрчилгээ, ур чадварын үнэлгээ,	0-5	35
		Бусад шаардлагатай мэргэжлийн ажилтны мэргэжил, Боловсролын гэрчилгээ	0-5	35
		Мэргэжил дээшлүүлсэн байдал	0-3	35
		Ажилтны нийгмийн хамгаалал, бичиг баримт, хувийн хэргийн бүрдэл	0-3	35
		Сургалт семинар, хурал, зөвлөгөөнд оролцсон, зохион байгуулсан байдал	0-3	35
3.	Сургалт- <u>дасгалжуулалтын</u> чанарын шалгуур	Хичээллэгчдийн бие бялдрын төвшингийн үнэлгээний судалгаа	0-5	35
		Хичээллэгчдийн үзүүлсэн амжилтын судалгаа	0-8	35
		Дасгалжуулагчдын үзүүлсэн	0-8	35

		амжилтын судалгаа		
		Хичээллэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа	0-5	35
		Зөвшөөрөл олгосон спортын холбооны тодорхойлолт	0-3	35
		Харьяа аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газрын тодорхойлолт	0-3	35

-oOo-

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны хамтарсан .../.... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

СПОРТЫН КЛУБИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний нэр	Зардлын хэмжээ /төгрөгөөр/
1.	Анх удаа магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубийн төлбөр	1,500,000
2.	Давтан магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан спортын клубийн төлбөр	1,000,000
3.	Магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны төлбөр	350,000
4.	Бэлтгэл ажлын арга зүйн зөвлөгөө өгсөн, явцын үнэлгээ болон дунд хугацааны үнэлгээ хийж, тайлан бичсэн мэргэжилтний ажлын хөлс (нэг спортын клубд)	45,000
5.	Хараат бус шинжээчийн багийн ахлагчийн ажлын хөлс (нэг спортын клубд нэг өдөр ажиллахад)	80,000
6.	Хараат бус шинжээчийн багийн гишүүний ажлын хөлс (нэг спортын клубд нэг өдөр ажиллахад)	60,000
7.	Зөвлөлийн хурлын зохион байгуулалтын зардал (нэг удаагийн хуралд)	250,000
8.	Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс (нэг удаагийн хуралд ороход)	56,000

-оОо-

